

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/12/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшсүрэн Утас: 51-261740 Цахим хаяг: tegshsurenb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.6 Худалдан авах, ажиллагааны гүйцэтгэл	19
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Харьяа байгууллагууд.....	23
5.3.2 Албан шаардлага	23
5.3.3 Зөвлөмж.....	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТБӨЯХ	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТГ	Татварын газар
ТЖАХ	Төрийн жинхэнэ албан хаагч
ТХ	Татварын хэлтэс
ТУБ	Татварын улсын байцаагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЦОГТНАРАН ТАНАА

2026.03.25 № 808
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны Татварын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Татварын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Татварын алба нь татварын чиг үүрэгт Татварын ерөнхий хуулийн 75 дугаар зүйлийн 75.1.1-д “Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах” гэж заасны дагуу Татварын албаны үйл ажиллагааны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан татвар төлөгчдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 оныг “Зөвлөн туслагч татварын алба” болох зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тус зорилтын хүрээнд төсвийг үр ашигтай, хэмнэлттэй хуваарилах зорилгоор Монгол Улсын хэмжээнд 33 албаны хэрэгжүүлэх “Сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөө” боловсруулан баталж, татварын албаны үйл ажиллагааг ил тод, нээлттэй, хүртээмжтэй хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хэвлэл, мэдээллийн байгууллагын судалгаа, хэрэглэгчийн хандалтын судалгааг гарган, үр дүнг үнэлж, дэвшилтэт технологи ашиглан татвар төлөгчдөд орон зай, цаг хугацааг үл харгалзан 24/7 цагаар тасралтгүй зөвлөгөө мэдээллээр хангах “Хиймэл оюун ухааны татварын зөвлөх”-ийг өөрийн хүчээр хөгжүүлж, тайлант онд амжилттай нэвтрүүлсэн, олон нийтийн татварын боловсролын түвшинг нэмэгдүүлэх зорилгоор телевизийн “Татварын булан” бий болгосон зэргээр зорилтот бүлэгт чиглэсэн ажлыг хэрэгжүүлснээр зардлыг бууруулж, мэдээлэл хэрэглэгчдийн тоог 126 хувиар нэмэгдүүлсэн байна.

Мөн Татварын ерөнхий газар нь тайлант онд Сангийн яамнаас олгосон нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын 378.9 тэрбум төгрөг, сугалаа урамшууллын 42.9 тэрбум төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын буцаан олголтын 97.5 тэрбум төгрөг, нийт 519.3 тэрбум төгрөгийн санхүүжилт, 509.8 тэрбум төгрөгийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Татварын алба нь 11,174.5 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 11,576.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 103.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 331.8 тэрбум төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 180.5 тэрбум төгрөг, дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар 136.3 тэрбум төгрөг, ус бохирдуулсны төлбөр 4.4 тэрбум төгрөгөөр тус тус давж биелснээс голлон шалтгаалсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд заасан орон тоог 9 хувь хүртэл бууруулах чиглэлийн дагуу Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн "Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоолоор Татварын ерөнхий газрыг 6 газар 6 хэлтэстэй, орон тооны дээд хязгаарыг 100 байхаар өөрчилж баталсан. Мөн татварын албаны орон тоог 1834 байсныг 1668 болгон 266 орон тоогоор бууруулахаар холбогдох баримт бичгийг боловсруулсан байна.

Тайлант онд гүйцэтгэлээр нийт 1220 албан хаагчтай ажилласан буюу 448 албан хаагч дутуу байгаа нь томилгоо хийгдээгүй албан тушаал 342, тэтгэвэрт гарсан 33, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 37, төрийн байгууллага хооронд шилжсэн 27, ажил олгогч чөлөөлсөн 9, нийт 79 албан хаагчийн оронд нөхөн томилгоо хийгээгүй зэрэгтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,520,380.3	5,370,399.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,663,297.4	1,945,264.4
33	АВЛАГА	712,176.8	1,581,863.8
35	БАРАА МАТЕРИАЛ	2,144,906.0	1,843,270.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	60,200,436.7	61,940,138.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	60,200,436.7	61,940,138.9
39200	Биет хөрөнгө	49,719,144.7	51,240,598.6
39300	Биет бус хөрөнгө	10,481,291.9	10,699,540.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	64,720,817.0	67,310,537.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	556,443.8	2,353,262.1
41300	Өглөг	448,691.7	1,989,314.1
41400	Урьдчилж орсон орлого	107,752.1	363,948.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	64,164,373.2	64,957,275.8
51	Засгийн газрын хувь оролцоо	64,164,373.2	64,957,275.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	20,015,564.3	16,728,950.9
51200	Хуримтлагдсан үр дүн	39,980,931.5	40,603,153.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,167,877.5	4,338,558.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	64,720,817.0	67,310,537.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	125,133,926.4	635,889,678.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,819,174.4	635,889,678.8
120	Нийтлэг татварын бус орлого	13,819,174.4	9,661,856.3
122	Тусламжийн орлого	-	626,227,822.6
1221	Хандив тусламж /дотоод/	-	626,227,822.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	111,314,752.0	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	103,820,349.7	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,346,498.6	-
1330	Төсвийн захирагчдаас	1,147,903.7	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	116,214,458.1	631,327,625.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	115,640,707.4	630,598,680.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,277,893.6	104,524,317.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,535,253.2	70,139,022.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,766,516.2	8,877,581.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,271,500.3	1,808,972.8
2104	Хангамж, бараа материалын зардал	1,900,570.9	1,650,904.6
2105	Нормативт зардал	18,847.9	875.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	524,025.6	491,502.9
2107	Томилолт, зочны зардал	675,073.6	371,099.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,393,978.2	9,986,961.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,192,127.7	11,197,398.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,362,813.8	526,074,363.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	523,998,298.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,568,634.1	2,076,064.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,764,485.4	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,694.4	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	0.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	573,750.7	728,944.4
2200	Дотоод эх үүсвэрээр	573,750.7	728,944.4

Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	8,919,468.3	4,562,053.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	546,548.5	3,299,731.9
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(546,548.5)	(3,299,731.9)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	8,372,919.8	1,262,321.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,015,564.3	4,167,877.5	31,601,339.7	55,784,781.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	6,671.9	6,671.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,015,564.3	4,167,877.5	31,608,011.7	55,791,453.4
9	Тайлант үеийн үр дүн	-	-	8,372,919.8	8,372,919.8
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,015,564.3	4,167,877.5	39,980,931.5	64,164,373.2
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	20,000.0	-	20,000.0
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,015,564.3	4,187,877.5	39,980,931.5	64,184,373.2
13	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	150,681.0	(640,100.0)	(489,419.0)
14	Тайлант үеийн үр дүн	-	-	1,262,321.6	1,262,321.6
15	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	20,015,564.3	4,338,558.5	40,603,153.1	64,957,275.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	589,595,418.0	632,247,146.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,593,007.7	632,247,146.0
120	Нийтлэг татварын бус орлого	6,593,007.7	5,311,552.7
122	Тусламжийн орлого	-	626,935,593.3
1221	Хандив тусламж /дотоод/	-	626,935,593.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	583,002,410.3	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	103,820,349.7	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	479,182,060.7	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	577,615,899.5	621,899,942.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	577,615,899.5	621,899,942.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97,974,189.5	94,227,211.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,714,804.1	70,048,848.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,674,862.0	8,939,696.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,271,200.3	1,804,131.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,703,834.1	1,267,660.3
2105	Нормативт зардал	578.2	180.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	630,178.3	520,368.3
2107	Томилолт, зочны зардал	627,039.2	303,146.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,258,399.4	10,387,924.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,093,293.9	955,256.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	479,641,710.0	527,672,730.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	469,529,861.3	525,366,986.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,628,528.9	2,074,972.7
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,288,055.4	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	195,264.4	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	230,771.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	11,979,518.5	10,347,203.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	12,100,414.7	10,065,236.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,100,414.7	10,065,236.8
2200	Дотоод эх үүсвэрээр	12,100,414.7	10,065,236.8

Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(12,100,414.7)	(10,065,236.8)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(120,896.2)	281,967.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,784,193.6	1,663,297.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,663,297.4	1,945,264.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	110,995,768,200.00	100,997,814,232.14	9,997,953,967.86	91.0
12	Татварын бус орлого	110,995,768,200.00	100,997,814,232.14	9,997,953,967.86	91.0
120	Нийтлэг татварын бус орлого	4,971,942,000.00	4,208,729,163.23	763,212,836.77	84.6
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	4,971,942,000.00	4,208,554,163.23	763,387,836.77	84.6
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	175,000.00	(175,000.00)	
122	Тусламжийн орлого	106,023,826,200.00	96,789,085,068.91	9,234,741,131.09	91.3
122005	Төсвөөс санхүүжих	106,023,826,200.00	96,789,085,068.91	9,234,741,131.09	91.3
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	110,995,768,200.00	100,997,814,232.14	9,997,953,967.86	91.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	104,789,368,200.00	94,791,723,854.14	9,997,644,345.86	90.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	102,459,301,000.00	92,960,423,312.88	9,498,877,687.12	90.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	71,223,982,400.00	67,673,738,162.32	3,550,244,237.68	95.0
210101	Үндсэн цалин	34,078,242,700.00	33,086,563,993.94	991,678,706.06	97.1
210102	Нэмэгдэл	18,931,556,300.00	17,449,406,339.72	1,482,149,960.28	92.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,602,713,000.00	4,587,446,626.60	15,266,373.40	99.7
210104	Урамшуулал	13,611,470,400.00	12,550,321,202.06	1,061,149,197.94	92.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,191,655,200.00	8,651,713,970.82	539,941,229.18	94.1
210201	Тэтгэврийн даатгал	6,295,359,700.00	5,980,416,689.52	314,943,010.48	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	725,502,700.00	690,422,425.83	35,080,274.17	95.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	362,580,100.00	350,717,439.22	11,862,660.78	96.7
210204	Ажилгүйдлийн даатгал	361,759,800.00	322,038,309.05	39,721,490.95	89.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,446,452,900.00	1,308,119,107.20	138,333,792.80	90.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,533,595,400.00	1,804,130,966.65	729,464,433.35	71.2
210301	Гэрэл, цахилгаан	523,584,800.00	389,141,714.30	134,443,085.70	74.3
210302	Түлш, халаалт	1,189,091,000.00	1,103,609,170.83	85,481,829.17	92.8
210303	Цэвэр, бохир ус	199,440,800.00	114,645,439.85	84,795,360.15	57.5
210304	Байрны түрээс	621,478,800.00	196,734,641.67	424,744,158.33	31.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,344,853,900.00	770,268,948.35	574,584,951.65	57.3
210401	Бичиг хэрэг	334,315,900.00	238,357,194.00	95,958,706.00	71.3
210402	Тээвэр, шатахуун	115,798,700.00	85,391,975.10	30,406,724.90	73.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	497,348,600.00	194,308,649.25	303,039,950.75	39.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	53,773,200.00	26,465,098.00	27,308,102.00	49.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	343,617,500.00	225,746,032.00	117,871,468.00	65.7
2105	Нормативт зардал	11,413,900.00	-	11,413,900.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,413,900.00	-	11,413,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	519,494,900.00	392,565,434.00	126,929,466.00	75.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,845,900.00	11,487,153.00	4,358,747.00	72.5
210602	Тавилга	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	139,939,400.00	9,868,000.00	130,071,400.00	7.1
210604	Урсгал засвар	355,709,600.00	363,210,281.00	(7,500,681.00)	102.1
2107	Томиллолт, зочны зардал	477,538,300.00	271,610,037.00	205,928,263.00	56.9
210701	Гадаад албан томилолт	32,730,600.00	23,224,045.00	9,506,555.00	71.0
210702	Дотоод албан томилолт	443,107,700.00	246,685,992.00	196,421,708.00	55.7
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,700,000.00	1,700,000.00	-	100.0

Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,913,180,400.00	13,157,561,760.74	3,755,618,639.26	77.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,137,671,700.00	4,486,627,486.18	1,651,044,213.82	73.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	49,513,300.00	5,267,300.00	44,246,000.00	10.6
210803	Даатгалын үйлчилгээ	72,455,100.00	29,152,036.00	43,303,064.00	40.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	10,080,900.00	8,526,329.50	1,554,570.50	84.6
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	29,515,600.00	812,100.00	28,703,500.00	2.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,046,772,000.00	4,067,885,397.06	1,978,886,602.94	67.3
210807	Газрын төлбөр	14,048,800.00	6,232,812.00	7,815,988.00	44.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,553,123,000.00	4,553,058,300.00	64,700.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	243,586,600.00	238,834,033.00	4,752,567.00	98.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,619,500.00	24,229,820.00	1,389,680.00	94.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	217,967,100.00	214,604,213.00	3,362,887.00	98.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,330,067,200.00	1,831,300,541.26	498,766,658.74	78.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,330,067,200.00	1,831,300,541.26	498,766,658.74	78.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,162,000.00	17,162,000.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,587,119,500.00	1,116,483,682.48	470,635,817.52	70.3
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	620,543,300.00	619,706,708.78	836,591.22	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	105,242,400.00	77,948,150.00	27,294,250.00	74.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,206,400,000.00	6,206,090,378.00	309,622.00	100.0
220001	Барилга байгууламж	1,509,900,000.00	1,509,681,828.00	218,172.00	100.0
222001	Тоног төхөөрөмж	4,696,500,000.00	4,696,408,550.00	91,450.00	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	33	33	-	66.7
610001	Төсвийн байгууллага	33	33	-	66.7
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1,668	1,220	448	73.1
620001	Удирдах ажилтан	60	51	9	85.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1,468	1,081	387	73.6
620003	Үйлчлэх ажилтан	140	88	52	62.9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,627	1,218	409	74.9
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,528	1,130	398	74.0
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	-	1	(1)	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	99	87	12	87.9
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	88	61	27	69.3
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	88	61	27	69.3

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		6,010,515,125.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		6,010,515,125.58
122	Тусламжийн орлого		6,010,515,125.58
1221	Хандив тусламж /дотоод/		6,010,515,125.58
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		6,010,515,125.58
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,372,490,907.68
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,966,911,696.30
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		671,112,521.60
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,774,953,214.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,754,953,414.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,662,148,414.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,374,379,616.67
210101	Үндсэн цалин		144,286,298.36
210102	Нэмэгдэл		1,866,952,670.71
210104	Урамшуулал		257,917,138.60
210105	Гэрээт ажлын хөлс		105,223,509.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		287,982,132.28
210201	Тэтгэврийн даатгал		231,310,931.82
210202	Тэтгэмжийн даатгал		14,460,664.01
210203	ҮОМШӨ-ний даатгал		7,228,763.08
210204	Ажилгүйдлийн даатгал		6,967,933.44
210205	Эрүүл мэндийн даатгал		28,013,839.93
2104	Хангамж, бараа материалын зардал		500,245,015.18
210401	Бичиг хэрэг		172,131,410.00
210402	Тээвэр, шатахуун		142,368,740.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		59,106,235.18
210404	Ном, хэвлэл		30,799,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		95,839,030.00
2105	Нормативт зардал		180,000.00
210502	Хоол, хүнс		180,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		162,207,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		12,569,500.00
210602	Тавилга		17,858,000.00
210604	Урсгал засвар		131,779,700.00
2107	Томилолт, зочны зардал		31,535,957.00
210702	Дотоод албан томилолт		31,535,957.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		633,006,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		559,280,058.00
210803	Даатгалын үйлчилгээ		1,406,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		72,297,422.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		672,612,093.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		492,325,663.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		180,286,430.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		92,805,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		92,805,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		5,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		87,805,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		19,999,800.00

Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2200	Дотоод эх үүсвэрээр		19,999,800.00
223001	Бусад хөрөнгө		19,999,800.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		1,235,561,910.65
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(1,235,561,910.65)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(1,235,561,910.65)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Татварын алба нь эрхэм зорилгоо “Татвар төлөгч хуулиар хүлээсэн татвар төлөх үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулахад оршино.” гэж тодорхойлсон ба Сангийн сайдын 2020 оны 04 тоот тушаалаар батлагдсан бүтэц, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Татварын ерөнхий газар нь эрхэм зорилгын хүрээнд Татварын албаны үйл ажиллагааны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг баталж, дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Татвар төлөгчийн эрэлтэд нийцсэн үйлчилгээ үзүүлж, татварын боловсролыг тасралтгүй түгээх;
- Засгийн газар, холбогдох байгууллагад татварын бодлого боловсруулах, зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Монгол Улсын хөгжлийн төлөө хууль тогтоомжид заасан орлогыг бүрдүүлэх;
- Ажлын туршлага, түншлэл, технологиор дамжуулан татварын хууль тогтоомжийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх;
- Оновчтой засаглал, дотоод хяналт, хараат бус хяналтаар дамжуулан шударга, хариуцлагатай байдлыг тасралтгүй сайжруулах.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д “төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Засгийн газрын 2025 оны 217 дугаар тогтоолыг үндэслэн Сангийн сайдын 195 дугаар тушаалын дагуу томилогдсон Татварын ерөнхий газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тайлант онд Татварын ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 33 татварын газар, хэлтсүүдийн санхүүгийн тайланг нэгтгэжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Татварын алба нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрмийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Татварын албаны үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;
- Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/З дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан;
- Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 240 дүгээр тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг

зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг шинэчлэн баталсан;

Татварын ерөнхий газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Татварын албаны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан "Улсын салбарын дотоод аудитын аргачлал", Татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/124 дүгээр тушаалаар баталсан "Дотоод аудитын журам"-ыг 2020 оны А/200 дугаар тушаалаар шинэчлэн баталсан, 2011 оны "Үндэсний татварын албанд дотоод эрсдэл тооцох журам" А/592, 2017 оны "Татварын ерөнхий газрын харьяа нэгжийн үйл ажиллагааны дотоод эрсдэл тооцох заавар" А/146, 2021 оны "Татварын албаны дотоод эрсдэлийн удирдлагын журам" А/73 дугаар тушаалуудыг мөрдөн ажилладаг. Тайлант онд хяналт шалгалтын ажил хийгдээгүй, Татварын ерөнхий газрын үйл ажиллагаанд Сангийн яамны Дотоод хяналт, аудитын газраас хяналт, шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Татварын ерөнхий газрын даргын 2020 оны А/156 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч холбогдох стандарт, хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан сайжруулах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос **2,589.7** сая төгрөгөөр буюу 4.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Мөнгөн хөрөнгө	1,663,297.4	1,945,264.4	281,967.0
Авлага	712,176.8	1,581,863.8	869,686.9
Бараа материал	2,144,906.1	1,843,270.8	(301,635.3)
Үндсэн хөрөнгө	60,200,436.7	61,940,138.9	1,739,702.2
Нийт хөрөнгө	64,720,817.0	67,310,537.9	2,589,720.9
Богино хугацаат өр төлбөр	448,691.7	1,989,314.1	1,540,622.4
Урьдчилж орсон орлого	107,752.1	363,948.0	256,195.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	64,164,373.2	64,957,275.8	792,902.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	64,720,817.0	67,310,537.9	2,589,720.9

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,945.3 сая төгрөг болж, өмнөх оноос 282.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	1.7	1.7	-
Банканд байгаа бэлэн мөнгө	1,663,295.8	1,945,262.7	281,967.0
Төрийн сангийн харилцах	1,019,023.0	786,405.1	(232,617.9)
Арилжааны банк дахь харилцах	644,272.8	1,158,857.7	514,584.9
Дүн	1,663,297.4	1,945,264.4	281,967.0

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Татварын ерөнхий газрын Төрийн сан дахь барьцаа хөрөнгийн данс дахь 771.7 сая төгрөг, ахмадын сан 77.9 сая төгрөг, арилжааны банкин дахь жуулчдын буцаан олголтын 1,080.9 сая төгрөг, дэнчин 14.7 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нэмэгдэхэд Чингэлтэй Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн барилгын гүйцэтгэлийн үлдэгдэл төлбөрийг Засгийн газрын 249 дүгээр тогтоолын дагуу хөрөнгө оруулалтын 198.0 сая төгрөг, жуулчдын буцаан олголтын арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 217.3 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, 109.5 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан. /Нийслэлийн ТГ 20.0 сая төгрөг, Орхон аймгийн ТГ 16.7 сая төгрөг, Өмнөговь аймгийн ТГ 5.0 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ТХ 10.4 сая төгрөг, ТEG 54.7 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн ТХ 2.7 сая төгрөг/;
- Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 4.6 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүжүүлсэн. /Дархан-Уул аймгийн ТГ 3.4 сая төгрөг, Орхон аймгийн ТГ 1.2 сая төгрөг/;
- Батлагдсан орон тооны хязгаараас илүү орон тоогоор ажилласан /Баян-Өлгийн аймгийн ТГ/;
- Нэмэлт санхүүжилтийн 66.7 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй /Дорнод аймгийн ТГ 1.7 сая төгрөг, Налайх дүүргийн ТХ 55.0 сая төгрөг, Ховд аймгийн ТГ 10.0 сая төгрөг/;
- нягтлан бодогчийн орон тоотой боловч ТУБ хавсран гүйцэтгэсэн нь дотоод хяналтыг сулруулах эрсдэл үүсгэсэн /Баянзүрх дүүргийн ТХ, Говьсүмбэр аймгийн ТГ 2.1 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ТХ, Чингэлтэй дүүргийн ТХ/;
- Төсөвт төлөвлөөгүй 467.6 сая төгрөгийн зардал гаргасан /Говьсүмбэр аймгийн ТГ 1.1 сая төгрөг, ТEG 466.5 сая төгрөг/;
- Дүүргийн ЗДТГ-аас нэмэлт санхүүжилтээр ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн боловч орлого, зарлагыг нэр данс зөрүү дансны ангиллаар дамжуулан гүйлгээ хийсэн /Сүхбаатар дүүргийн ТХ 172.4 сая төгрөг/;
- Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн 34.5 сая төгрөгийн актыг улсын төсөвт төвлөрүүлээгүй /Өмнөговь аймгийн ТГ/;
- Орон нутгийн төсвөөс орж ирсэн нэмэлт санхүүжилтийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй /Орхон аймгийн ТГ 19.1 сая төгрөг/;
- Урамшуулал, шагнал давхардуулан 375.0 сая төгрөг олгосон /Булган аймгийн ТГ 29.5 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн ТГ 1.5 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ТГ 0.3 сая төгрөг, Налайх дүүргийн ТХ 7.5 сая төгрөг, Орхон аймгийн ТГ 91.0 сая төгрөг, Өмнөговь аймгийн ТГ 21.6 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ТХ 24.9 сая төгрөг, Ховд аймгийн ТГ 198.7 сая төгрөг/;
- Үйл ажиллагааны чиглэл таарахгүй аж ахйн нэгээс 34.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн /Ховд аймгийн ТГ 10.7 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн ТХ 23.8 сая төгрөг/;
- Цалин, НДШ, ХХОАТ-ыг зөрүүтэй тооцож 8.8 сая төгрөг олгосон /Баянхонгор аймгийн ТГ 4.9 сая төгрөг, Говь-Алтай аймгийн ТГ 0.7 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн ТГ 0.6 сая төгрөг, Завхан аймгийн ТГ 1.8 сая төгрөг, Сүхбаатар аймгийн ТГ 0.2 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн ТГ 0.6 сая төгрөг/.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,581.9 сая төгрөг болж, өмнөх оноос 869.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татаас, санхүүжилтийн авлага	688,490.1	922,643.3	234,153.1
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	-	33,734.2	33,734.2
Бусад авлага	23,686.7	625,486.3	601,799.6
Байгууллагаас авах авлага	19,703.4	620,407.1	
Хувь хүмүүсээс авах авлага	3,983.3	5,079.1	1,095.8
Дүн	712,176.8	1,581,863.8	869,686.9

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Авлагын өсөлтөд бусад авлагын 601.8 сая төгрөг, татаас санхүүжилтийн авлагын 234.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал: Нэмэлт санхүүжилтийн орлогоос эрх нээгдээгүйгээс Татварын ерөнхий газар 888.1 сая төгрөг, харьяа 4 татварын хэлтэс 34.5 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан, Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасан, онцгой албан татварын тэмдгийн үйлдвэрлэх явцад үйлдвэрийн ачааллаас хамааран 227.7 сая төгрөгийн авлага үүссэн зэргээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- НДШ-ийг илүү тооцож шилжүүлэн авлага үүсгэсэн /Архангай аймгийн ТХ 1.7 сая төгрөг/;
- Насжилт өндөртэй авлагыг шийдвэрлэх талаар арга хэмжээ аваагүй. /Баянзүрх дүүргийн ТХ 2.2 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ТХ .07 сая төгрөг, Нийслэлийн ТГ 10.3 сая төгрөг/

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 1,843.3 сая төгрөг болж, өмнөх оноос 301.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	20.2	17.2	(3.0)
Эм боох материал	399.1	217.6	(181.5)
Бэлэн бүтээгдэхүүн	6,302.9	6,300.1	(2.8)
Хангамжийн материал	2,133,756.9	1,831,523.9	(302,233.0)
Бичиг хэргийн материал	367,463.5	170,661.2	(196,802.3)
Аж ахуйн материал	861,644.3	817,613.9	(44,030.4)
Сэлбэг хэрэгсэл	10,090.0	10,683.8	593.8
Түлш, шатах тослох материал	67,141.8	19,613.1	(47,528.7)
Барилгын засварын материал	6,533.8	6,547.5	13.7
Хүнсний материал	3,810.1	165.7	(3,644.4)
Бусад хангамжийн материал	817,073.4	806,238.7	(10,834.6)
Мал амьтад	4,427.0	5,212.0	785.0
Дүн	2,144,906.1	1,843,270.8	(301,635.3)

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бараа материалын дансны бууралтад хангамжийн материал 302.2 сая төгрөг, бичиг хэргийн материал 196.8 сая төгрөг, түлш шатах төслөх материал 47.5 сая төгрөг, аж ахуйн материал 44.0 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд Татварын ерөнхий газрын урсгал зардлын төсвөөс нийт 4,630.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэсэн бөгөөд үүний 4,325.3 сая төгрөг нь Онцгой албан татварын тэмдэг захиалан хэвлүүлж архи, тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарт 4,326.2 сая төгрөгийн тэмдэгтийг олгосон байна.

Тайлант оны эцэст нийт 1,843.3 сая төгрөгийн бараа материалыг Татварын ерөнхий газрын даргын 2025 оны А/162 тоот тушаалаар байгуулагдсан тооллогын комисс тоолж баталгаажуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Газрын төлбөрийн зөвлөмжийн тараах материалыг бараа материалын дансаар дамжуулаагүй, анхан шатны баримт бүрдэлгүй зарцуулсан. /Дархан-Уул аймгийн ТГ 7.0 сая төгрөг/
- Бараа материалын тайланд орлогын баримт, шаардах хуудас дутуу бүртгээсэн. /Өвөрхангай аймгийн ТХ 5.2 сая төгрөг/;
- Татварын газрын гадна хаяг 2024 онд гүйцэтгэх компани руу шилжүүлж бараа материалын бүртгэлд авсан боловч гэрээний дагуу ажлаа бүрэн гүйцэт хийгээгүй. /Ховд аймгийн ТХ 2.4 сая төгрөг/;
- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 3 ширхэг хөрөнгийг бүртгээсэн. /Чингэлтэй дүүргийн ТХ 26.9 сая төгрөг/

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 61,940.1 сая төгрөг болж, өмнөх оноос 1,739.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	49,719,144.7	51,240,598.6	1,521,453.9
Барилга, байгууламж, орон сууц	25,323,955.6	25,610,215.9	286,260.3
Авто-тээврийн хэрэгсэл	1,064,808.2	2,942,363.4	1,877,555.2
Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,162,675.3	5,556,213.7	(1,606,461.7)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,540,555.0	1,488,027.1	(52,527.9)
Бусад үндсэн хөрөнгө	115,523.8	209,822.2	94,298.3
Дуусаагүй барилга, байгууламж	14,508,242.3	15,429,571.8	921,329.6
Ном	3,384.6	4,384.6	1,000.0
Биет бус хөрөнгө	10,481,291.9	10,699,540.3	218,248.4
Программ хангамж	30,408.9	3,761,029.5	3,730,620.6
Биет бус хөрөнгө	10,450,883.0	6,938,510.8	(3,512,372.2)
Дүн	60,200,436.7	61,940,138.9	1,739,702.3

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 1,646.6 сая төгрөгийн өртөгтэй 513 ширхэг компьютер техник хэрэгсэл, 1,569.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Татварын албадын парк шинэчлэлийн хүрээнд 1,483.0 сая төгрөгийн өртөгтэй 9 ширхэг тээврийн хэрэгсэл, урсгал үйл ажиллагааны зардлаас 15.5 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 3,356.1 сая төгрөгийн биет бус хөрөнгийг тус тус худалдан авсан байна. Үүнээс 5 ширхэг 601.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг Том татвар төлөгчийн газар, Хан-Уул дүүргийн татварын хэлтэс, Хөвсгөл аймгийн татварын газар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-1/46 тоот албан бичгээр Баянзүрх дүүргийн татварын хэлтэс, Дархан-уул аймгийн татварын газруудад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-2/1174 албан бичгээр тус тус балансаас балансад шилжүүлжээ.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-1/1693 албан бичгийн дагуу Сэлэнгэ аймгийн татварын газар, Булган аймгийн татварын газруудад Татварын ерөнхий газрын балансад бүртгэлтэй 267.0 сая төгрөгийн өртөг бүхий 2 автомашиныг шилжүүлэн өмч хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнасан байна

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 547 дугаар тогтоолын дагуу Том татвар төлөгчийн газар, Нийслэлийн татварын газар, 21 аймаг, 9 дүүргийн татварын газар хэлтэст 1,125.4 сая төгрөгийн өртөг бүхий 439 ширхэг тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн байна.

Татварын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 184 нэрийн нийт 1,154.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 3 ширхэг тоног төхөөрөмжийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 544 дүгээр тогтоолын дагуу дахин үнэлүүлж, хугацааг сунгаж, нийт үнийг 476.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоож бүртгэлд тусган тайлагнасан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 692 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй 1,401.3 сая төгрөгийн 65 ширхэг тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, биет бус хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн акталж устгасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Газар эзэмших эрхийн хугацаа дууссан /Архангай аймгийн ТХ 25.0 сая төгрөг/;
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаагүй. /Дундговь аймгийн ТГ, Өмнөговь аймгийн ТГ, Хан-Уул дүүргийн ТХ-11.9 сая төгрөг/;
- Үндсэн хөрөнгийн тооллогыг хангалтгүй хийсэн, акталсан үндсэн хөрөнгийн дүнг тооллогын дүнд оруулж тоолсон. /Сонгинохайрхан дүүргийн ТХ 25.8 сая төгрөг/;
- Хөрөнгийг зөв дансанд ангилж бүртгээгүй, хөрөнгөд тавих дотоод хяналт хангалтгүй. /Өвөрхангай аймгийн ТХ/

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,989.3 сая төгрөг болж, өмнөх оноос 1,540.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон өглөг	-	3,638.0	3,638.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	7,081.6	7,081.6
Байгууллагад төлөх өглөг	23,720.1	796,206.2	772,486.2
Хувь хүмүүст өгөх өглөг	421,396.4	1,081,292.8	659,896.4
Татварын өглөг /ТӨҮГ/	3,354.0	53,777.7	50,423.7
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	221.2	47,317.8	47,096.6
Дүн	448,691.7	1,989,314.1	1,540,622.4

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос нийт 1,540.6 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөг 772.5 сая төгрөг, хувь хүмүүст төлөх өглөг 659.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна. Тухайлбал:

- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.19-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12-р сарын 13-ний өдрийн 445 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын жуулчдын хувийн хэрэгцээнд зориулж худалдаж авсан бараанд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын төлбөрийн баримтыг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ийн дагуу гадаадын жуулчдын буцаан олголттой холбоотой арилжааны банкны дансны 1,080.7 сая төгрөгийн үлдэгдлийг тайлант оны хувь хүмүүст төлөх өглөгт;
- Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн барилгын гүйцэтгэлийн үлдэгдэл төлбөрийг Засгийн газрын 249 дүгээр тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 786.3 сая төгрөг, оны эцэст нэмэлт санхүүжилтийн дансанд нэр данс андуурч орсон 9.9 сая төгрөгийг тус тус байгууллагад төлөх өглөг дансанд тус тус бүртгэж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Батлагдсан төсөвт багтаан үр дүнгийн урамшууллыг олгоогүйгээс ХХОАТ-т 4.1 сая төгрөг, даатгуулагчаас төлөх НДШ-ийн зардалд 8.1 сая төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан. /Дархан-Уул аймгийн ТГ/;
- Тайлант онд НДШ-ийн дутуу тооцоолсноос өглөгтэй гарсан байна. /Завхан аймгийн ТХ 1.7 сая төгрөг, Налайх дүүргийн ТХ 0.1 сая төгрөг/;
- Байгууллагад төлөх өглөг 1.1 сая төгрөг, хувь хүнд төлөх өглөг 0.2 сая төгрөг, нийт 1.3 сая төгрөгийн өглөг үүссэн. /Багануур дүүргийн ТХ 1.3 сая төгрөг/.

3.4.6 Урьдчилж орсон орлого

Урьдчилж орсон орлого 363.9 сая төгрөг болж өмнөх оноос 256.2 сая төгрөгөөр өссөн нь Татварын ерөнхий газрын онцгой албан татварын тэмдэгтийг оны эцэс үйлдвэрийн ачааллаас хамааран хэвлэн нийлүүлж чадаагүйгээс урьдчилж орсон орлогоор бүртгэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 7. Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж орсон орлого	107,752.1	363,948.0	256,195.9
Дүн	107,752.1	363,948.0	256,195.9

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 64,957.3 сая төгрөг болж, өмнөх оноос 792.9 сая төгрөгөөр өссөн тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	20,015,564.3	16,728,950.9	(3,286,613.4)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	3,286,613.4	3,286,613.4
Хуримтлагдсан үр дүн	39,980,931.5	40,603,153.1	622,221.6
Өмнөх үеийн үр дүн	31,608,011.7	39,340,831.5	7,732,819.8
Тайлант үеийн үр дүн	8,372,919.8	1,262,321.6	(7,110,598.2)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,167,877.5	4,338,558.5	170,681.0
Дүн	64,164,373.2	64,957,275.8	792,902.6

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Татварын ерөнхий газар нь 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 188,768.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 4,971.9 сая төгрөг, нийт 193,739.9 сая төгрөгөөр тоохон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 80,959.7 сая төгрөгөөр бууруулж, 112,781.2 сая төгрөгөөр баталсан байна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Татварын ерөнхий газрын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 11,174,408.2 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 4,361.7 сая төгрөг, нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1,348.8 сая төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардлыг

584.2 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эд хогшил, урсгал засварын зардлыг 525.0 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 903.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 166.5 сая төгрөг, бусад зардлыг 47.5 сая төгрөгөөр тус тус бууруулж, Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэх урсгал зардлын эх үүсвэрийг нийт 104,844.3 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардалд 96,789.1 сая төгрөг санхүүжилт авч, 9,234.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн, туслах үйл ажиллагааны орлогоос 4,208.7 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 9. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	11,174,408,224.3	11,576,274,370.1	(401,866,145.8)	103.6
Нийт дүн	11,174,408,224.3	11,576,274,370.1	(401,866,145.8)	103.6

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Татварын байгууллага нь 11,174,408.2 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 11,576,274.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 103.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 331,796.7 сая төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 180,508.4 сая төгрөг, дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар 136,295.0 сая төгрөг, ус бохирдуулсны төлбөр 4,381.1 сая төгрөгөөр тус тус давж биелснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 10. Туслах үйл ажиллагааны орлого

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	4,971,942.0	4,208,729.2	763,212.8	84.6
Нийт дүн	4,971,942.0	4,208,729.2	763,212.8	84.6

Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний биелэлт 84.6 хувь буюу 763.2 сая төгрөгөөр тасарсан нь бүх төрлийн цагаан архи, ликёр, кордиал ба спиртлэг бусад ундаа болон бүх төрлийн коньяк, виски, ром, джинд ногдох онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 96,789.1 сая төгрөг буюу 91.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 7,084.6 сая төгрөг, харуул хамгаалалтын зардлыг 403.4 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 498.8 сая төгрөг, нүүлгэн шилжүүлэх зардлыг 210.0 сая төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг 987.6 сая төгрөг, холбооны суваг ашигласны хөлсийг 231.5 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжийг 498.8 сая төгрөг, мэдээлэл, сурталчилгааны зардлыг 1.5 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70205	Татвар хураалт, орлого бүрдүүлэлт	106,023,826.2	96,789,085.1	9,234,741.1	91.3
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	91,349,687.3	84,265,066.7	7,084,620.6	92.2
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	1,445,787.2	458,140.3	987,646.9	31.7
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	113,676.4	112,176.4	1,500.0	98.7
80219	Харуул, хамгаалалтын зардал	1,511,711.1	1,108,282.1	403,429.0	73.3
80220	Холбооны суваг ашигласны хөлс	1,668,333.2	1,436,803.9	231,529.3	86.1
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	1,374,163.8	1,347,224.7	26,939.1	98.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	2,330,067.2	1,831,300.5	498,766.7	78.6
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	24,000.0	24,000.0	-	100.0
80918	Бусад	6,206,400.0	6,206,090.4	309.6	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан тушаалтныг цомхотгож ажилласан байна.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх хэсэг, Татварын ерөнхий газрын даргын 2024 оны А-12 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.3 дахь заалт дагуу аймаг, дүүргийн Татварын хэлтсийн дарга нар тушаал гарган алба хаагчдын хоолны мөнгөнд 5,000.00-18,000.00 төгрөг, унааны мөнгөнд 0-6,000.00 төгрөг зэрэг харилцан адилгүй байдлаар олгож байна.

Татварын ерөнхий газрын даргын харьяа байгууллагуудын хэмжээнд 264.5 сая төгрөгийн 55 хурал цуглаан зохион байгуулах арга хэмжээ төлөвлөснөөс 217.7 сая төгрөгийн 33 хурал, зөвлөгөөн зохион байгуулсан байна.

Татварын албаны хэмжээнд хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг 2 хувь хүн, 33 ахуй нэгжтэй нийт 257.6 сая төгрөгийн гэрээ байгуулж гүйцэтгэлээр 287.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Татварын ерөнхий газрын хэмжээнд үйл ажиллагаанд ашиглаж байгаа 8,835.2 сая төгрөгийн 19 төрлийн программ хангамж бүртгэлтэй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нийт 6,010.5 сая төгрөгийн нэмэлт орлогын эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Засаг дарга нараас Татварын газар, хэлтсийн үйл ажиллагааг дэмжих, зарим үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зэргээр нийт 21 албанд 2,372.5 сая төгрөгийн санхүүжилт;
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,966.9 сая төгрөг;
- Төсөвт байгууллагын өмнөх оны туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө давснаар хуваарилсан 671.1 сая төгрөг,

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардалд 2,662.4 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 500.2 сая төгрөг, норматив зардалд 0.2 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 162.7 сая төгрөг, томилолт, зочны зардалд 31.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 633.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 672.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 20.0 сая төгрөгийг тус тус зарцуулж, 425.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэн, 922.6 сая төгрөгийн үлдэгдлийг Сангийн яамтай тооцоо нийлж, татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6 Худалдан авах, ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 11,717.0 сая төгрөгийн 13, харьцуулалтын аргаар 133.8 сая төгрөгийн 2, шууд худалдан авалтын аргаар 70.5 сая төгрөгийн 4, нийт 11,921.4 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулахаар тусгасан байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 15,429.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд санхүүжих 1,000.0 сая төгрөг;
- Урсгал төсвөөс 10,921.8 сая төгрөг.

Гүйцэтгэлээр ерөнхий гэрээгээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 9,158.3 сая төгрөгийн 9 худалдан авалт, харьцуулалтын аргаар 84.0 сая төгрөгийн 1 худалдан авалт, шууд худалдан авалтын аргаар 13.6 сая төгрөгийн 1, нийт 9,255.9 сая төгрөгийн хөрөнгө, бараа, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авалт хийхдээ гэрээ байгуулаагүй, 204.1 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн /Баянгол дүүргийн ТХ 31.5 сая төгрөг, Нийслэлийн ТГ 31.5 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ТХ 22.7 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ТХ 29.8 сая төгрөг, ТЕГ 88.6 сая төгрөг/;
- Худалдан авалтын 86.4 сая төгрөгийн мэдээллийг цахим мэдээллийн системд мэдээллээгүй /Баянгол дүүргийн ТХ 49.5 сая төгрөг, Налайх дүүргийн ТХ 36.9 сая төгрөг/.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Татварын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, аудитор Б.Тэгшсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Татварын ерөнхий газар 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/700 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 115,839.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,158.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 634,627.3 сая төгрөг болж, 2024 оноос 5.5 дахин нэмэгдсэн нь нөлөө бүхий өөрчлөлт гэж үзлээ.

Материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 634,627.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,346.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуваарилагдсан төсвийг үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулах, хуульд тусгагдсан хэмнэлтийн горим, бусад арга хэмжээг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоход анхаарч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

4.4.1.1 Түүврийн байгууллага

Илрүүлэлт: Татварын ерөнхий газар нь шилэн дансны мэдээллийн системд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3,992.7 сая төгрөгийн зарлагын 50 гүйлгээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх.

Мөн тайлант онд татварын албаны хэмжээнд шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээллийг хугацаа хороож мэдээлсэн, огт мэдээлээгүй нийт 1,782.2 сая төгрөгийн 10 зөрчил илэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны цахим системд 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээний дүнг хоцроож мэдээлсэн. /Дорноговь аймгийн ТГ 77.5 сая төгрөг, Орхон аймгийн ТГ, Өвөрхангай аймгийн ТГ, Сонгинохайрхан дүүргийн ТХ 320.6 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ТХ, ТЕГ, Хан-Уул дүүргийн ТХ 77.4 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн ТХ/;
- Шилэн дансны цахим системд 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээний дүнг мэдээлээгүй. /Дархан-Уул аймгийн ТГ 189.4 сая төгрөг, Налайх дүүргийн ТХ 1,158.0 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ТХ 36.7 сая төгрөг/.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Харьяа байгууллагуудын аудитаар бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1,740.1 сая төгрөгийн 15 зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Орон нутгийн төсвөөс үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх санхүүжилтэд 1,302.6 сая төгрөгийг давхардуулан авч зарцуулсан. /Багануур дүүргийн ТХ 6.8 сая төгрөг, Багахангай дүүргийн ТХ 3.4 сая төгрөг, Баянгол дүүргийн ТХ 96.0 сая төгрөг, Баянзүргийн дүүргийн ТХ 238.9 сая төгрөг, Налайх дүүргийн ТХ 150.0 сая төгрөг, Нийслэлийн ТГ 96.4 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ТХ 132.4 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ТХ 357.2 сая төгрөг, Хан-Уул дүүргийн ТХ 22.4 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ТГ 76.1 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн ТХ 123.1 сая төгрөг/;
- Татварын улсын байцаагч нарт сар, улирлын урамшууллыг ажлын үр дүнг бодитой тооцоогүй, хавтгайруулан олгосон /Хөвсгөл аймгийн ТГ 351.1 сая төгрөг/;
- Татварын алба төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад байхгүй Интерактив би ай би ХХК-ны Эмиралд программыг нягтлан бодох бүртгэлд ашиглаж байна.

4.4.2.1 Түүврийн байгууллага

Илрүүлэлт: Татварын ерөнхий газар нь төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад байхгүй Интерактив би ай би ХХК-ны Эмиралд программыг нягтлан бодох бүртгэлд ашиглаж байна. Тус программ нь ерөнхий журналын Дт, Кт гүйлгээний мэдээллийг буруу ангилан бүртгэдэг, ашиглахад төвөгтэй, сайжруулалт хийгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программыг нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу дараах компаниудын программууд нь Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөлтэй программын жагсаалтад бүртгэлгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зарласан тусгай зөвшөөрөлтэй санхүүгийн программыг санхүүгийн үйл ажиллагаанд ашиглах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн харьяа татварын газар, хэлтсийн аудитаар илэрсэн дээрх асуудлууд хууль тогтоомжийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны гуравдугаар улирлын санхүүгийн нэгтгэсэн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө болон зардлын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг асуудлын бүртгэлээр шалгагдагч байгууллагад танилцуулж, залруулагдах боломжгүй 466.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, 15.0 сая төгрөгийн 1 зөвлөмж, 88.6 сая төгрөгийн хариуцлага тооцох 1 албан шаардлагыг жилийн эцсийн аудитад нэгтгэсэн болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 6.1 сая төгрөгийн төлбөрийн 2 акт, хүргүүлсэн 81.5 сая төгрөгийн 5 албан шаардлагаас хэрэгжсэн 4, хэрэгжилт хангалтгүй 1, нийт биелэлт 91.0 хувьтай байна.

Хүснэгт 12. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төсвийн төвлөрүүлэн захирагч					
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Дүн	1	-	1	-	100.0
Төсвийн шууд захирагч					
Төлбөрийн акт	2	6,085.7	2	6,085.7	100.0
Албан шаардлага	4	81,512.5	3	-	75.0
Зөвлөмж	2	42,059.4	2	42,059.4	100.0
Дүн	8	129,657.6	7	48,145.1	89.3
Нийт дүн	9	129,657.6	8	48,145.1	91.0

Өмнөх аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчил давтагдан гарсан тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар, аж ахуй нэгжийн орлогын албан татварын буцаалт, сугалааны хонжворын урамшуулалд нийт 519,294.9 сая төгрөгийн санхүүжилт авч 509,845.4 сая төгрөгийн урамшуулал олгож 8,790.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн боловч хувь хүний нууцтай холбоотой асуудал тул нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн анхан шатны баримт руу тулган баталгаажуулах, төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал нөхцөл үүссэн тул Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар анхаанч үзэх шаардлагатай;
- Татварын албаны улсын төсөвт төвлөрүүлэх татварын хүү торгуулийн 35,000.0 сая төгрөгийн орлогын 2025 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэл гараагүй байгаа нь улсын төсвийн орлого тасрах, бодит эрсдэлийг үүсгэсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 624.8 сая төгрөгийн 4 зөрчил¹ илэрсэнд 521.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 88.6 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 15.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 1,609.2 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,737.1 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” өгсөн.

5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 33 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 26 байгууллагад /Өөрчлөлтгүй/, 3 байгууллагад /Хязгаарлалттай/ дүгнэлт гаргаж, 4 байгууллага, 1 хөрөнгө оруулалтын 1 данс түүвэрт хамрагдсан.

Харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,609.2 сая төгрөгийн 72 зөрчил илэрснээс 24.4 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 967.5 сая төгрөгийн зөрчилд 28 албан шаардлага хүргүүлж, 261.0 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 3 албан шаардлага хүргүүлж, 345.6 сая төгрөгийн зөрчилд 27 зөвлөмж өгсөн байна.

5.3 Түүврийн байгууллага

5.3.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах төлөвлөгөөнд тусгагдаагүй 466.5 сая төгрөгийн хөрөнгийн худалдан авалтыг хийсэн байна. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн 3 багцын тендерийн худалдан авалтыг зохион байгуулахдаа Багц-1 туулах чадвар сайтай 3 тээврийн хэрэгслийг нэгжийн 196.3 сая төгрөгөөр тооцож, нийт 589.0 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн боловч Татварын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/77, 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/81 дүгээр тушаалуудаар төсөвт өртгийг өөрчилж 505.0 сая төгрөг болгон Тоёота RAV-4 маркын тээврийн хэрэгслийг 148.5 сая төгрөгөөр, Тоёото ланд круйзер 300 маркын авто машиныг 356.5 сая төгрөгөөр нийт 2 тээврийн хэрэгсэл худалдан авсан;
- Багц 2-т төв суурин газар ашиглах бага оврын суудлын тээврийн хэрэгслийг нэгжийг 195.0 сая төгрөгөөр тооцоолж 3 тээврийн хэрэгслийг 585.0 сая төгрөгөөр тооцсон боловч гүйцэтгэлээр 3 төрлийн 5 тээврийн хэрэгслийг худалдан авалтыг 580.0 сая төгрөгөөр буюу 199.0 сая төгрөгийн 2 тээврийн хэрэгсэл илүү худалдан авсан. Тээврийн хэрэгслийн нийлүүлэх гэрээний хугацааг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл 2 сараар сунгахдаа гэрээний гэрээний тусгай нөхцөлийн 2.9-д заасан нотлох баримтыг шаардлагатай хугацааны хамт баталгаажуулж ирүүлээгүй байна.

Мөн дээрх худалдан авсан Тоёото ланд круйзер 300 маркын 1 тээврийн хэрэгслийг орон нутгийн татварын байгууллагад шилжүүлэхээр төлөвлөсөн боловч өөрийн хөрөнгөнөөс машины хуулга наалт, салхины шил, доторлогоо хийн нум хийлгэхэд 9.0 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй зардлыг урсгал засварын зардлаас зарцуулж, үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх;" 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх" Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-т "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно", 40.1.1-т "захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах;" 40.2.1-т "энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;" 2025.05.30-ны ТEG01/35 дугаар гэрээний ерөнхий нөхцөлийн 2.9-д "ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, төсвийн төсөлд тусгаж төлөвлөөгүй ажил, үйлчилгээг санхүүжүүлж хөрөнгө бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоох **албан шаардлага** хүргүүллээ.

Илрүүлэлт 2: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, тэвчиж болох нийт 54.7 сая төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд:

- Спортын арга хэмжээ зохион байгуулахад 37.3 сая төгрөг;
- Үйл ажиллагааны чиглэл таарахгүй цэцэрлэгжүүлэлтийн "УБТ гарден" ХХК-аас "Татварын байгууллагын 1, 2 дугаар давхрын ариун цэврийн өрөөний хоорондох хана болон сангийн засварт" гэсэн утгатай 17.4 сая төгрөг;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх;" 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах. сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон тэвчиж болох зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоох **албан шаардлага** хүргүүллээ.

Илрүүлэлт 3: Гэрээгээр гүйцэтгүүлсэн зарим үйлчилгээнүүдийг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, аж ахуйн нэгжийг сонгохдоо үнийн санал авалгүй шууд гэрээ байгуулж санхүүжилт олгосон 88.6 сая төгрөг олгосон, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Макснет ХХК-д 36.0 сая төгрөг;
- Цахим толь ХХК-д 11.7 сая төгрөг;
- Гөү смарт ТМ-д 19.8 сая төгрөг;
- Смарт дрийм лүүк 18.6 сая төгрөг;
- Энх-Арслан ХХК-тай Олон нийттэй харилцах албаны чиг үүргийг давхардуулан мониторингийн үйлчилгээ авахад 19.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 14.2 сая төгрөгийг тус тус олгосон.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай

төлөвлөж, батална.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 2.1-т "Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна.", 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ажиллаагүй, төлөвлөгөөнд тусгагдаж батлагдаагүй ажил үйлчилгээг санхүүжүүлсэн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй буруутай албан хаагчид **хариуцлага тооцуулах албан шаардлага** хүргүүлээ.

5.3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.3.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч

1. Нэмэлт төсвийн гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Татварын ерөнхий газар түүний харьяа байгууллагууд босоо тогтолцоотой улсын төсвийн байгууллага боловч орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд татварын газар хэлтсийн үйл ажиллагааг дэмжих, зарим үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зэргээр 28 албанд 4,419.2 сая төгрөг, Нийслэлийн татварын газар, дүүргүүдийн татварын хэлтэст шат шатны Засаг даргаас АТБӨЯХ-ийн албан татварын орлогыг бүрдүүлэхэд зориулан 647.1 сая төгрөгийн урсгал зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгож байгаа нь төсвөөс гадуурх зарцуулалтыг үүсгэж байна.

Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.", 24 дүгээр зүйлийн 24.5-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна.", 47 дугаар зүйлийн 47.1.Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно: 47.1.1.төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж;", 47.1.2-т "төсвийн жилийн явцад Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл;", 47.1.3-т "Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө;", 47.1.4-т "дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө;", 47.1.5-д "төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого;", 47.1.6-д "төсвийн урамшуулал, 47.1.7-д "Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого.", 47.1.8-д "гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын олсон нэмэлт орлого.", 47.2.Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна." 47.3-т "Энэ хуулийн 47.1.2, 47.1.6-д заасан орлогыг зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулна.", 42.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын төсвийн зохицуулалтыг зөвхөн тухайн жилийн төсөвт тодотгол хийж шийдвэрлэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улсын төсөвт байгууллагын нэмэлт санхүүжилтээр орж ирж байгаа орон нутгийн төсвийн хуваарилалт, татварын албаны алба хаагчдын хангамжийн асуудлыг хуульд нийцүүлэн нэг мөр шийдвэрлэх асуудлыг судалж, төсвийн гадуурх зарцуулалтыг үүсгэхгүй байх.

2. Харьяа байгууллагын аудиттай холбоотой

Илрүүлэлт 1: Татварын ерөнхий газрын харьяа байгууллагуудын зөрчил өмнөх оноос 124.9 сая төгрөгөөр буурсан боловч Татварын ерөнхий газрын аппаратын санхүүгийн тайланд илэрсэн зөрчил өмнөх оноос 576.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.”, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.1-т “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна..

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг дараагийн аудитаар 30.0 хүртэлх хувиар бууруулж ажиллах.

5.3.3.2 Түүврийн байгууллага

1. Нэмэлт төсвийн гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт 2: Орон нутагт ажиллах албан хаагчдын томилолтын зардал 15.0 сая төгрөгийг хувь хүмүүсийн дансанд шилжүүлэлгүй жижиг мөнгөн сангаар дамжуулан бэлнээр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.Бэлэн мөнгөний кассын ажиллагаа: 2.2-т “Төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картан дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар /ЖМС/-ын дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж, урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Томилолтын төсвийг холбогдох албан хаагчийн дансанд, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан үйлчилгээ, бараа материалын төлбөрийг тус байгууллагын дансанд тус тус харилцах данснаас шилжүүлж байх чиглэл баримтлах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
								Залруулсан		Зөвлөмж өгсөн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай аймгийн ТХ	1	10,756.5			1	10,756.5	1	10,756.5		
2	Багахангай дүүргийн ТХ	1	5,045.0	1	5,045.0			1	5,045.0		
3	Баянгол дүүргийн ТХ	2	206,034.4			2	206,034.4	2	206,034.4		
4	Баянзүрх дүүргийн ТХ	2	2,932.8			2	2,932.8	2	2,932.8		
5	Баян-Өлгий аймгийн ТГ	1	1,531.0	1	1,531.0			1	1,531.0		
6	Булган аймгийн ТГ	5	14,582.5			5	14,582.5	5	14,582.5		
7	Говь-Алтай аймгийн ТХ	1	431.1			1	431.1	1	431.1		
8	Говьсүмбэр аймгийн ТГ	8	12,294.3	4	6,367.7	4	5,926.4	8	12,294.3		
9	Дархан-Уул аймгийн ТГ	2	251,653.0			2	251,653.0	2	251,653.0		
10	Дорноговь аймгийн ТХ	2	104,683.4			2	104,683.4	2	104,683.4		
11	Дундговь аймгийн ТГ	2	4,504.7	1	2,387.4	1	2,117.4	2	4,504.8		
12	Завхан аймгийн ТХ	1	24,567.2			1	24,567.2	1	24,567.2		
13	Налайх дүүргийн ТХ	2	50,187.1			2	50,187.1	2	50,187.1		
14	Нийслэлийн ТГ	2	123,564.1			2	123,564.1	2	123,564.1		
15	Орхон аймгийн ТГ	1	63,788.1			1	63,788.1	1	63,788.1		
16	Өмнөговь аймгийн ТГ	2	8,639.7			2	8,639.7	2	8,639.7		
17	Сонгинохайрхан дүүргийн ТХ	3	74,532.1			3	74,532.1	3	74,532.1		
18	Сүхбаатар аймгийн ТГ	2	37,263.4			2	37,263.4	2	37,263.4		
19	Сүхбаатар дүүргийн ТХ	2	9,132.2			2	9,132.2	2	9,132.2		
20	Төв аймгийн ТГ	1	44,427.6			1	44,427.6	1	44,427.6		
21	Увс аймгийн ТГ	1	1,579.6			1	1,579.6	1	1,579.6		
22	Хан-Уул дүүргийн ТХ	5	22,964.3			5	22,964.3	5	22,964.3		
23	Чингэлтэй дүүргийн ТХ	2	20,648.2			2	20,648.2	2	20,648.2		
	Нийт дүн	51	1,095,742.3	7	15,331.1	44	1,080,411.0	51	1,095,742.3	-	-

Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил

/мянган төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт санхүүгийн зөрчил		Санхүүгийн зөрчил Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хуулийн байгууллагад шилжүүлэх		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТ-ны тоо	Мөнгөн дүн	Тоо
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ															
1	Татварын ерөнхий газрын дарга	2	-					2	-						
	Дүн	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-	-	-
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ															
1	Архангай аймгийн ТХ	2	26,756.5	1	1,756.5	1	25,000.0	-	-						
2	Багануур дүүргийн ТХ	1	1,277.5					1	1,277.5						
3	Баянгол дүүргийн ТХ	1	31,500.0			1	31,500.0								
4	Баянзүрх дүүргийн ТХ	3	21,178.5	-	-	2	21,178.5	1	-						
5	Баян-Өлгий аймгийн ТГ	2	2,263.2	1	2,263.2	-	-	1	-						
6	Баянхонгор аймгийн ТГ	1	4,870.9	1	4,870.9										
7	Булган аймгийн ТГ	1	29,500.0			1	29,500.0								
8	Говь-Алтай аймгийн ТХ	1	650.1	1	650.1										
9	Говьсүмбэр аймгийн ТГ	6	5,259.7	3	571.6	2	2,606.3	1	2,081.8						
10	Дархан-Уул аймгийн ТГ	4	22,910.1	1	307.8	-	-	3	22,602.3						
11	Дорнод аймгийн ТГ	1	1,670.0			1	1,670.0								
12	Дундговь аймгийн ТГ	1	-					1	-						
13	Завхан аймгийн ТХ	2	3,482.4			2	3,482.4	-	-						
14	Налайх дүүргийн ТаХ	3	62,671.6	-	-	2	62,545.5	1	126.1						
15	Нийслэлийн ТГ	3	61,845.7	-	-	2	41,845.7	1	20,000.0						
16	Орхон аймгийн ТГ	5	128,114.4	2	1,417.8	2	109,996.6	1	16,700.0						
17	Өвөрхангай аймгийн ТХ	2	5,151.7			1	5,151.7	1	-						
18	Өмнөговь аймгийн ТГ	5	26,506.4	-	-	3	26,506.4	1	-	1	1	-			
19	Сонгинохайрхан дүүргийн ТХ	6	48,303.2	-	-	3	23,389.8	3	24,913.4						
20	Сүхбаатар дүүргийн ТХ	7	212,822.9	1	2,000.0	2	38,188.8	3	252.0	1	1	172,382.1			
21	Сэлэнгэ аймгийн ТГ	1	602.2	1	602.2										
22	Татварын ерөнхий газар	4	624,813.8	-	-	2	521,213.8	1	15,000.0	1	1	88,600.0			
23	Хан-Уул дүүргийн ТХ	1	11,884.6					1	11,884.6						
24	Ховд аймгийн ТХ	4	221,824.4	1	10,000.0	-	-	2	201,115.4				1	10,709.0	
25	Чингэлтэй дүүргийн ТХ	5	53,359.1	-	-	1	23,750.0	4	29,609.1						
	Дүн	72	1,609,218.9	13	24,440.1	28	967,525.5	27	345,562.2	3	3	260,982.1	1	10,709.0	
	Нийт дүн	74	1,609,218.9	13	24,440.1	28	967,525.5	29	345,562.2	3	3	260,982.1	1	10,709.0	

Нийцлийн аудитын зөрчил

/мянган төгрөгөөр/

Шалгагдагч байгууллагын нэр	Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хуулийн байгууллагад шилжүүлэх	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТ-ны тоо	мөнгө н дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой													
Дархан-Уул аймгийн ТГ	1	189,416.6			1	189,416.6							
Дорноговь аймгийн ТХ	1	-					1	-					
Налайх дүүргийн ТХ	1	1,157,963.4			1	1,157,963.4							
Орхон аймгийн ТГ	1	-					1	-					
Өвөрхангай аймгийн ТХ	1	-					1	-					
Сонгинохайрхан дүүргийн ТХ	1	320,641.2					1	320,641.2					
Сүхбаатар дүүргийн ТХ	1	36,722.0					1	36,722.0					
Татварын ерөнхий газар	1	-					1	-					
Хан-Уул дүүргийн ТХ	1	77,416.5					1	77,416.5					
Чингэлтэй дүүргийн ТХ	1	-					1	-					
Дүн	10	1,782,159.7	-	-	2	1,347,380.0	8	434,779.7	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой													
Багануур дүүргийн ТХ	1	6,799.7					1	6,799.7					
Багахангай дүүргийн ТХ	1	3,400.0					1	3,400.0					
Баянгол дүүргийн ТХ	2	145,537.0					2	145,537.0					
Баянзүрх дүүргийн ТХ	1	238,850.7					1	238,850.7					
Налайх дүүргийн ТХ	2	186,863.7			1	36,872.1	1	149,991.6					
Нийслэлийн ТГ	1	96,399.9					1	96,399.9					
Сонгинохайрхан дүүргийн ТХ	1	132,415.0					1	132,415.0					
Сүхбаатар дүүргийн ТХ	1	357,172.7					1	357,172.7					
Татварын ерөнхий газар	1	-					1	-					
Хан-Уул дүүргийн ТХ	1	22,400.0					1	22,400.0					
Хөвсгөл аймгийн ТХ	2	427,149.9					2	427,149.9					
Чингэлтэй дүүргийн ТХ	1	123,129.8					1	123,129.8					
Дүн	15	1,740,118.4	-	-	1	36,872.1	14	1,703,246.3	-	-	-	-	-
Нийт дүн	25	3,522,278.1	-	-	3	1,384,252.1	22	2,138,026.0	-	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1221/А0160075

Улаанбаатар хот

САГ - 2026/12/НА - СТА - ТТЗ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрээгээр гүйцэтгүүлсэн зарим үйлчилгээнүүдийг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, аж ахуйн нэгжийг сонгохдоо үнийн санал авалгүй шууд гэрээ байгуулж санхүүжилт олгосон 88,600,000.00 /Наян найман сая зургаан зуун мянган/ төгрөг олгосон, өмнөх аудитаар өгсөн 792/А0160075 дугаартай албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Макснет ХХК-д 36,000,000.00 /Гучин зургаан сая/ төгрөг;
- Цахим толь ХХК-д 11,700,000.00 /Арван нэгэн сая долоон зуун мянган/ төгрөг;
- Гөү смарт ТМ-д 19,800,000.00 /Арван есөн сая найман зуун мянган/ төгрөг;
- Смарт дрийм лүүк 18,600,000.00 /Арван есөн сая зургаан зуун мянган/ төгрөг;
- Энх-Арслан ХХК-тай Олон нийттэй харилцах албаны чиг үүргийг давхардуулан мониторингийн үйлчилгээ авахад 19,200,000.00 /Арван есөн сая хоёр зуун мянган/ төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 14,200,000.00 /Арван дөрвөн сая хоёр зуун мянган/ төгрөгийг тус тус олгосон.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 2.1-т "Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна.", 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Aiban Shaardlaga\2026\0325 SAG-53.Docx

1526181905

талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ажиллаагүй, төлөвлөгөөнд тусгагдаж батлагдаагүй ажил үйлчилгээг санхүүжүүлсэн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй Худалдан авах ажиллагааны төлөвлөлт хариуцсан буруутай албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Цогтнаран)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Б.ТЭГШСҮРЭН

9006109
ATA16087
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1222/А0160075

Улаанбаатар хот

САГ-2026/12/НА-СТА-ТТЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах төлөвлөгөөнд тусгагдаагүй 466,500,000.00 /Дөрвөн зуун жаран зургаан сая таван зуун мянган/ төгрөгийн хөрөнгийн худалдан авалтыг хийсэн байна. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн 3 багцын тендерийн худалдан авалтыг зохион байгуулахдаа Багц-1 туулах чадвар сайтай 3 тээврийн хэрэгслийг нэгжийн 196,333,333.00 /Нэг зуун ерэн зургаан сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван/ төгрөгөөр тооцож, нийт 589,000,000.00 /Таван зуун наян есөн сая/ төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн боловч Татварын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/77, 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/81 дүгээр тушаалуудаар төсөвт өртгийг өөрчилж 505,000,000.00 /Таван зуун таван сая/ төгрөг болгон Тоёота RAV-4 маркын тээврийн хэрэгслийг 148,500,000.00 /Нэг зуун дөчин найман сая таван зуун мянган/ төгрөгөөр, Тоёото ланд круйзер 300 маркын авто машиныг 356,500,000.00 /Гурван зуун тавин зургаан сая таван зуун мянган/ төгрөгөөр нийт 2 тээврийн хэрэгсэл худалдан авсан;
- Багц 2-т төв суурин газар ашиглах бага оврын суудлын тээврийн хэрэгслийг нэгжийг 195,000,000.00 /Нэг зуун ерэн таван сая/ төгрөгөөр тооцоолж 3 тээврийн хэрэгслийг 585,000,000.00 /Таван зуун наян таван сая/ төгрөгөөр тооцсон боловч гүйцэтгэлээр 3 төрлийн 5 тээврийн хэрэгслийг худалдан авалтыг 580,000,000.00 /Таван зуун наян сая/ төгрөгөөр буюу 199,000,000.00 /Нэг зуун ерэн есөн сая/ төгрөгийн 2 тээврийн хэрэгсэл илүү худалдан авсан. Тээврийн хэрэгслийн нийлүүлэх гэрээний хугацааг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл 2 сараар сунгахдаа гэрээний тусгай нөхцөлийн 2.9-д заасан нотлох баримтыг шаардлагатай хугацааны хамт баталгаажуулж ирүүлээгүй байна.

Мөн дээрх худалдан авсан Тоёото ланд круйзер 300 маркын 1 тээврийн хэрэгслийг орон нутгийн татварын байгууллагад шилжүүлэхээр төлөвлөсөн боловч өөрийн хөрөнгөнөөс машины хуулга наалт, салхины шил, доторлогоо хийн нум хийлгэхэд 9,000,000.00 /Есөн сая/ төгрөгийн төлөвлөгдөөгүй зардлыг урсгал засварын зардлаас зарцуулж, үр ашиггүй зардлыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх;" 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх" Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-т "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно", 40.1.1-т "захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах;" 40.2.1-т "энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;" 2025.05.30-ны ТEG01/35 дугаар гэрээний ерөнхий нөхцөлийн 2.9-д "ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, төсвийн төсөлд тусгаж төлөвлөөгүй ажил, үйлчилгээг санхүүжүүлж хөрөнгө бэлтгэдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Цогтнаран), Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Л.Бямбадорж), Ерөнхий санхүүч (Б.Бямбасүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		П.ЧАНЦАЛДУЛАМ
АХЛАХ АУДИТОР		Ж.НЯМЦЭЦЭГ
АУДИТОР		Б.ТЭГШСҮРЭН

9005109
ATA16087
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1223/A0160075

Улаанбаатар хот

САГ-2026/12/НА -СТА -ТТЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Татварын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, тэвчиж болох нийт 54,713,777.00 /Тавин долоон сая долоон зуун арван гурван мянга долоон зуун далан долоон/ төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд:

- Спортын арга хэмжээ зохион байгуулахад 37,266,387.00 /Гучин долоон сая хоёр зуун жаран зургаан сая гурван зуун наян долоон/ төгрөг;
- Үйл ажиллагааны чиглэл таарахгүй цэцэрлэгжүүлэлтийн "УБТ гарден" ХХК-аас "Татварын байгууллагын 1, 2 дугаар давхрын ариун цэврийн ерөөний хоорондох хана болон сангийн засварт" гэсэн утгатай 17,447,390.00 /Арван долоон сая дөрвөн зуун дөчин долоон сая гурван зуун гучин/ төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх;" 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах. сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон тэвчиж болох зардлыг санхүүжүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Цогтнاران), Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Л.Бямбадорж), Ерөнхий санхүүч (Б.Бямбасүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б.Цогтнاران*
АУДИТЫН МЕНЕЖЕР *Л.Бямбадорж*
АХЛАХ АУДИТОР *Б.Бямбасүрэн*
АУДИТОР *Ц.Наранчимэг*
П.Чанцалдулам
Ж.Нямцэцэг
Б.Тэгшсүрэн

